

БНСУ-ЫН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ОНЦЛОГ

С.Энхцэцэг*

***Abstract:** In the middle of 1990's, the UNDP was implementing the development program "Tumen River" zone in the border area of Russia, China and North Korea. This document laid the foundation for the development of the North-East Asian region based on multilateral cooperation between South Korea and Mongolia. In 1991, Mongolia and Korea established diplomatic relations, and in 2011, the two countries reached the level of "comprehensive partnership". Since 1991, The Republic of Korea is considered as Mongolia's "third neighbor" and has been supporting Mongolian democracy, increasing trade and investment relations, and lending through Official Development Assistants (ODA) over the last 26 years. Since 1991, Mongolians have been studying and working in Korea. As a result, we have more active cultural and humanitarian exchanges than any other Asian countries. Mongolia and South Korea have been paying more attention to strengthen its Northeast Asian cooperation in Asia-Pacific region, and have been trying to start economic integration in the region.*

Key words: South Korean Foreign Policy Strategy, Energy policy, FTA, EPA

* * *

Түүхэн үүднээс авч үзвэл Монгол, Солонгосын ард түмэн 1000 жилийн харилцааны түүхтэй гэж үздэг. 1991 онд Монгол Улс, БНСУ дипломат харилцаа тогтоож, хоёр талын харилцаа 2011 онд “иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хүрсэн юм. Өнөөгийн хоёр орны хүрсэн харилцааны түвшинг өргөжүүлэн “стратегийн иж бүрэн түншлэл”-ийн хэмжээнд хүргэх цаг нь болжээ. БНСУ нь Монгол Улсын гадаад харилцааны “гуравдагч хөрш” орнуудын нэг бөгөөд 1991 оноос хойш өнгөрсөн 27 жилийн хугацаанд Монголд өрнөсөн ардчиллыг тууштай дэмжиж, худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаагаа нэмэгдүүлж, ХАЁТ-ийг үзүүлсээр ирсэн юм.

1991 оноос 2017 он хүртэл хугацаанд МУ-ын Ерөнхийлөгч 4 удаа, УИХ-ын дарга 4 удаа, МУ-ын Ерөнхий Сайдуд 3 удаа, ГХЯ-ны сайд 6 удаа БНСУ-д айлчилсан бол Солонгосын талаас Ерөнхийлөгч 4 удаа, Үндэсний Ассемблейн Дарга 3 удаа, Ерөнхий сайд 2 удаа, ГХЯ-ны Сайд 4 удаа тус бүр Монголд харилцан айлчилж төрийн дээд хэмжээний айлчлал тогтмолжсон байна. Энэ хугацаанд олон монголчууд БНСУ-д сурч, ажиллаж ирсэн тул иргэд хоорондын харилцаа өсч, түүнийг даган соёл, хүмүүнлэгийн үйл ажиллагаа идэвхитэй явагдаж ирсэн нь бусад Азийн орнуудаас онцлогтой байдаг.

Монгол, БНСУ нь АНД-н бүс нутгийн ЗХА дахь хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд ихээхэн анхаарч тус бүс нутагт эдийн засгийн интеграцийг эрчимжүүлэхийг чармайж ирсэн боловч БНАСАУ-ын цөмийн туршилт, улс төрийн

бодлогоос хамааран амжилтанд хүрээгүй одоо ч Солонгосын Хойгийн асуудал хурцдмал, түгшүүртэй байна.

Евразийн бүс нутагт Монголын эзэнт их гүрэн байгуулж явсан эртний түүхтэй, Төв Азид цээжинд орших Монгол улс нь 3 сая хүн амтай, ХБО боловч, газар нутгийн хэмжээгээр БНСУ-аас хэд дахин том, нүүрс, алт, зэс, уран, ховор металл, газрын ховор элемент, газрын тосны нөөцөөр баялаг, байгалийн баялагаа олборлож эхэлж байгаа орон юм. Хэдийгээр далайд гарцгүй боловч БНХУ, ОХУ зэрэг өргөн уудам нутагтай, олон сая хүн амтай 2 том зах зээлийн дунд оршдог тул ГХО-ыг татах боломжтой, эдийн засгийн нээлттэй бодлого хэрэгжүүлж буй ардчилсан орон юм. Тиймээс БНСУ, Япон зэрэг ЗХА-ийн хөгжингүй орнуудын анхаарлыг зүй ёсоор татаж ирсэн, стратегийн тэргүүлэх сонирхол, ач холбогдлыг Монголд өгч байгаа тул цаашид Хятад улсын “Нэг бүс, нэг зам” бодлогын 1 чиглэл болсон “цайны зам”-д тавигдах Евразийн бүс нутгийн тээвэр, ложистик, худалдаа, эдийн засгийн томоохон сүлжээнд хамтран оролцох таатай боломж нээгдэж байгаа нь аль алинд нь геополитик, геоэдийн засгийн өргөн боломжийг олгож байна.

XXI ЗУУНЫ БНСУ-ЫН ГАДААД УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГОД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ, ОНЦЛОГ

Солонгосын дайнаар сүйтгэгдсэн газар тариалангийн эдийн засгаа дэлхийн тэргүүлэх 20 эдийн засгийн (G-20) нэг болтол хөгжүүлсэн Өмнөд Солонгос улс улс төрийн хувьд 1988 оноос ардчилалд шилжсэн түүхтэй. Олон улсын харилцаан дахь хүчний тухай ойлголт өөрчлөгдөхийн хэрээр Солонгос улсын үүргийн талаарх ойлголт өөрчлөгдөж АНУ-ын Ази дахь гол холбоотны үүргээс хальж олон улсын хариуцлагатай оролцогч болохоо бүрэн ойлгосон явдал юм. Солонгосын нийгмийн ардчилал нь глобал орчинд энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, хүний эрхийг дээдлэх явдлыг гол зарчмаа болгож үздэг. Дэлхий нийтийн тулгамдсан асуудал хурцдахын хэрээр глобал хамтын ажиллагаа идэвхижиж түүнийг даган БНСУ-ын бүс нутаг болон олон улсын хамтын ажиллагаанд гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж байна. Үүний бодит илрэл нь Солонгос хөгжлийн тусламжийн бодлогоо өргөжүүлж НҮБ ийн энхийг сахиулах ажиллагаанд илүү идэвхитэй оролцох болсон юм. ДНБ-ны хэмжээгээр аваад үзвэл эдийн засаг, эрүүл мэнд, хүн ам, цэргийн чадавхаараа Өмнөд Солонгос нь олон улсад дундаж хүчний улсын (middle power) эгнээнд орно. Одоо Солонгос хүйтэн дайны үеийн холбоотны төдийхөн байдлаасаа гарч хүчтэй эдийн засаг бүхий улс болж чаджээ.

XX зууны БНСУ-ын гадаад бодлогод хүчтэй нөлөөлж байсан Хойд Солонгосын коммунизмын эсрэг үзэл, Японы колоничлолын эсрэг үзэл, “Халимнуудын дундах сам хорхой” буюу бүс нутгийн хүчирхэг их гүрнүүдийн дунд хавчуулагдаж үйл ажиллагаа нь хязгаарлагдаж байдаг“ гэх үзэл санаа цаг үеийн аясаар өөрчлөгдөн хувьсаж байна. XXI зуунд Солонгос хоёр талт харилцаанаас олон талт харилцаанд шилжиж терроризм, гэмт хэрэг, уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний хямрал, шашны зөрчил гээд ямар ч асуудал байсан дэлхийн аюулгүй байдал энх тайвантай

холбоотой бол түүнийг шийдвэрлэхэд оролцох замаар улсынхаа нэр хүндийг өндөрт өргөх, давхар олон улсын үүргээ биелүүлж байгаа юм.

БНСУ-н гадаад бодлого дараах чиг шугамыг баримталж байна:

- Стратегийн түншлэлд чиглэсэн бүс нутгийн дипломат ажиллагааг баримтлах
- Хойд Солонгосын асуудалд ахиц гаргахад хүчин чармайлт гаргах
- Дэлхийн хамтын ажиллагааны сүлжээнд гүнзгий нэвтэрч, олон талт дипломат ажиллагааг идэвхитэй явуулах
- Эдийн засгийн дипломат ажиллагааны хүрээнд ажлын байр нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх
- Гадаад улс орнуудад аюулгүй системийг өргөжүүлэх
- Олон нийтийн дипломат ажиллагаанд шинэ боломж нээх²³⁸ хэмээн албан ёсоор хэмээн тодорхойлжээ.

Түүхэн үүднээс авч үзвэл Өмнөд Солонгосын XX зууны сүүл, XXI эхэн үеийн гадаад бодлогын онцлогыг гурван хэсэгт хуваан авч үзэж болох юм. Үүнд:

1. Умардыг чиглэсэн нордполитик бодлого
2. Солонгосын хойгоос хальж гадагшаа чиглэсэн “Глобал Солонгос” стратеги
3. Евразийн санаачилга

Өмнөд Солонгосын “Нордполитик” нь анхны эмэгтэй ерөнхийлөгч асан Пак Гын Хэгийн эцэг Пак Чон Хигийн үед гарч ирсэн бодлого юм. Энэ бодлогод 1980-аад оны сүүл 1990-ээд оны эхэн үед томоохон ахиц дэвшил гарсан гэж үздэг. Нордполитик нь Солонгосын хойгт аюулгүй байдал, энх тайвныг бэхжүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг хүртэхийн тулд Еврази тивийг урагшлуулах гэсэн хоёр үндсэн зорилготой. Үүнээс гадна, нордполитикийг зах зээлийн төвтэй эсвэл энх тайван, аюулгүй байдлын төвтэй гэж хоёр хуваана. Пак Чон Хэ, Ро Тай Ву болон Ким Дае-Жун нарын Засгийн газар Хойд Солонгостой энх тайван, аюулгүй байдлын төвтэй нордполитикийн харилцааг чухалчилж байсан бол Ким Ён Сам болон Ли Мюн Бак нар зах зээлийн төвтэй нордполитикийн харилцааг чухалчилж байв. Ру Му-Хугийн Засгийн газар дээрх хоёр төвийн дунджийг тэнцвэртэй барьж байсан²³⁹ гэж үздэг байна.

“Глобал Солонгос” стратеги бодлогын гол үзэл санаа бол Солонгос улс зөвхөн Солонгосын хойгийн асуудлаас хальж, гадаад бодлого үндэсний ашиг сонирхолдоо тохирсон дэлхийн хэмжээний нээлттэй бодлого явуулах гэж үзэж болно. Global Korea буюу БНСУ-ын гадагшаа чиглэсэн бодлогыг 3 хэсэгт хуваан үзэж болно.

²³⁸ Diplomatic white paper 2016., p. 25

²³⁹ Мөн тэнд

1. Дэлхийн хариуцлагатай тоглогч (оролцогч)

Гадаад нэр хүнд болон үндэсний ашиг сонирхол хоорондын холбоог ч “Глобал Солонгос” стратегидаа тусгажээ. Үндэсний ашиг сонирхол нь дэлхийн хүн амын нийгмийн халамж, гадаад хууль тогтоомж цаашлаад манлайлалтай үндэсний ашиг сонирхолоо хослуулах аргыг ашигладаг байна. Энэ утгаараа олон улсад нэр хүндээ өсгөхийн тулд олон улсын хурал уулзалтуудыг Солонгос улс удаа дараа зохион байгуулж спортын арга хэмжээнээс авахуулаад улс төр, эдийн засаг, цөмийн аюулгүй байдлын асуудлаарх дээд хэмжээний томоохон уулзалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулсаар байна.

Олон улсын гэрээ, хэлэлцээрийг байгуулах, дагаж мөрдөх, олон улсын хууль, гэрээ эрх зүйг дагаж мөрдөх оновчтой хэрэгжүүлэх нь олон улсын хамтын ажиллагааны гол үндэс юм. Тиймээс ч 1948 онд БНСУ байгуулагдсанаас хойш Солонгосын засгийн газар 2015 он хүртэл нийт 3124 гэрээ байгуулж, түүний 2464 нь 2 талын, 660 нь олон талынх байжээ. Засгийн газрын гадаад харилцаа тэлснээр байгуулсан гэрээ хэлэлцээрийн тоо мөн адил ихэссэн. Ялангуяа, 1990 оноос хойш огцом өсөж 2011-2015 оны хооронд 379 (328 нь 2 талт, 51 олон талт) гэрээг байгуулжээ.²⁴⁰ Энэхүү байдлаараа БНСУ нь олон улсын болоод үндэстэн дамнасан байгууллага дахь оролцоогоо эрс идэвхижүүлж байна. Солонгос улс нь Олон улсын далайн байгууллага (ИМО), Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын комисс (IPCC), НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл (ECOSOC) зэрэг голлох салбарууд тэр дундаа энх тайван, аюулгүй байдал, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 гаруй олон улсын байгууллагыг даргалж байна.²⁴¹

2. Эдийн засгийн хүчтэй, нөлөө бүхий тоглогч

Солонгос нь 1996 онд хөгжингүй орнуудын бүлэг болох (ОУХХАБ)-д нэгдсэн, 1997 онд ОУВС хөгжингүй эдийн засаг гэдэг ангилалд хамруулсан байдаг. Солонгос улс нь 2009 онд хөгжлийн тусламж авагч орноос хандивлагч орон болж хувирсан юм. Дэлхийд ДНБ-ны хэмжээгээр 11 дэх том эдийн засаг, дэлхийн тэргүүлэх аж үйлдвэржсэн 10 улсын нэг, олон улсын худалдаанд тэргүүлэгч 20 улсын нэг бөгөөд гадаад худалдаанаас хэт хамааралтай улсын тоонд ордог.

Тиймээс ч БНСУ-ын анхны эмэгтэй ерөнхийлөгч асан Пак Ин Хэ 2013 онд тангараг өргөх үгэндээ тус улсын олон улсын эдийн засгаас учруулж болох эрсдэлд өртөмтгий байдал нэмэгдэж байгаа нь тус улсад тулгамдаж буй томоохон бэрхшээлүүдийн нэг гэж онцолжээ.²⁴² Энэхүү асуудлаа шийдвэрлэхийн тулд эдийн засгийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, ялангуяа дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан эдийн засгийн хөгжлийн стратегиа шинэчлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, гадаад зах зээлээ тэлж өргөжүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагаагааг эрчимжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж байна.

²⁴⁰ Diplomatic white paper 2016., p. 29

²⁴¹ Мөн тэнд

²⁴² Мөн тэнд.

3. Соёлын хамааралтай тоглогч

2000-аад оны эхээр Солонгосын гадаад бодлогын үүрэгт өөрчлөлт орж зөөлөн хүчний бодлогыг түлхүү хөгжүүлэхдээ соёлын үндсэрхэг үзлээр дамжуулж улс төрийн давуу байдлыг бий болгох аргыг сонгосон гэж үзэж болох юм. Солонгосын талаарх төсөөлөл болон эдийн засгийн нөлөөг сайжруулахын тулд Олон улсын спортын наадам зохион байгуулж соёл, спортын дипломат ажиллагаан дээр төвлөрдөг.²⁴³ Үүгээрээ ч К-поп, К-хоолны олон улсын фестиваль Солонгосын талаарх асуулт хариулт, видео уралдаан зэргийг KBS, MBC болон Arirang сувгуудтай хамтран ажиллаж зохион байгуулдаг байгаа.²⁴⁴ 2015 онд Солонгосын Сан нь 65 улсын 151 Гадаадын Их Сургуулийн 170 хичээлд хувь нэмрээ оруулахаас гадна 24 улсад Солонгос судлалтай холбоотой 47 академийн үйл ажиллагааг дэмжжээ.

Гадаад бодлогын гурав дахь *“Евразийн санаачилга”* нь БНСУ-ын анхны эмэгтэй Ерөнхийлөгч асан Пак Гын Хэгийн санаачлан хэрэгжүүлж буй бодлого юм. 2013 онд Ерөнхийлөгч асан Пак Гын Хэ *“Нэг тив, бүтээлч тив, энх тайван тив”* уриан дор *“Евразийн санаачилга”*-ын гол зорилго нь Евразийн нутаг дэвсгэр дамнасан тээвэр, эрчим хүч, худалдааны нэгдсэн сүлжээг бий болгох явдал юм. Энэ хүрээнд *“Экспресс Торгоны зам”* буюу БНСУ-ын Пусан хотоос Европ хүрэх авто болон төмөр замын сүлжээ мөн хойд мөсөн далайгаар дамжин шинэ далайн маршрут бий болгохоор төлөвлөжээ. Энэхүү тээврийн интеграци бий болсноор чөлөөт худалдааны асар том бүс байгуулагдаж, улмаар улс хоорондын худалдааны саад тотгорыг арилна хэмээн үзэж байна.

Энэхүү Евразийн санаачилга нь гурван хэсгээс бүрдэнэ.

1. **Геополитикийн хувьд:** Өмнөд Солонгос нь АНУ болон Хятад гэсэн хоёр түнш оронтой харилцаатай. Энэ хоёр их гүрэнтэй харилцах харилцаанд тэнцвэрийг барих шаардлага гарч ирж байгаа ч улс төрийн хувьд аль нэгийг нь сонгох шахаанд орох талтай. Солонгос-Америкийн эвсэл нь Солонгосын дайны дараа БНСУ-ын аюулгүй байдлын үндэс болсоор ирсэн. БНАСАУ-ын цөмийн зэвсгийн аюул Өмнөд Солонгосыг заналхийлж байгаа тул АНУ-БНСУ харилцаа гүнзгийрэхгүй байхын аргагүй. Гэхдээ хоёр том гүрний дунд тэнцвэрийг олно гэдэг хэцүү. Өмнөд Солонгосыг *“тэнхлэгийн гүрэн”* байх болно гэсэн Евразийн дипломат санаачилга магадгүй хариулт болох биз.
2. **Геоэдийн засгийн хувьд:** энэхүү санаачилга нь Өмнөд Солонгос улсыг Евразийн эдийн засгийн интеграцид оруулахаас гадна энэ бүс нутгийн нөлөө бүхий улс ложистик, тээвэр, эрчим хүч, шинжлэх ухаан, техник технологи, соёл зэрэг олон талт эдийн засгийн төсөлд оролцох боломж байгаа юм. Евразийн олон талт эдийн засгийн хамтын ажиллагаа нь эрчим хүч, тээвэр, харилцаа холбооны сүлжээний хүрээнд транс-Евразийн коридор төслийн хүрээнд хэрэгжих юм. Энэ санаачилга нь Солонгосын эдийн засгийн

²⁴³ Diplomatic white paper 2016., p. 357-358

²⁴⁴ Мөн тэнд

өсөлтийг урагшлуулах ач тустай гэж судлаачид дүгнэж байна. Түлхүүр үг нь “creative” буюу бүтээлч бөгөөд энэ нь Солонгосын эдийн засгийг бүтээлч эдийн засаг руу хувиргах хамгийн гол үүргийг гүйцэтгэнэ.

- 3. Аюулгүй байдлын салбарт:** Солонгосын хойгийн аюулгүй байдлыг сайжруулах төсөл хэрэгжих юм. Хойд Солонгостой хамтран энэ асуудлаар олон талт эдийн засгийн хамтын ажиллагаа өрнүүлэхээр яригдаж байсан ч эцэст нь өөрчлөлт орсон билээ. Үүнтэй холбоотойгоор Ерөнхийлөгч асан Пакийн Засгийн газар гадаад бодлогын хүрээнд “NAPCI” бүс нутгийн улсуудтай олон талт хамтын ажиллагаа өрнүүлэх, нөгөөтэйгүүр, Солонгосын хойгт итгэлцлийг бэхжүүлж үндсэн суурийг тавихад оршино. NAPCI буюу Зүүн Хойд Азид тогтвортой энх тайван болон хөгжил дэвшлийг байгуулах олон талт хамтын ажиллагааны сан юм. NAPCI нь Ерөнхийлөгч асан Пак Гын Хэгийн итгэлцлийн засгийн газрын гол зарчим бөгөөд аливаа маргаан, асуудлуудыг харилцаа холбоо, хамтын ажиллагаагаар солих нь БНСУ-ын зорилго юм.²⁴⁵ Хятад, Орос, Монгол, Япон зэрэг 29 улс, НҮБ, ЕХ зэрэг 8 олон улсын байгууллага дэмжсэн нь 1 том ялалт байв.

Гурвалсан хамтын ажиллагааны чуулга уулзалт: Хятад-БНСУ-Япон:

БНСУ-ын санаачилга, хүчин чармайлтаар Хятад, БНСУ, Японы гурвалсан хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлж бүс нутгийн асуудлыг хэлэлцэх, 3 улсын хамтын ажиллагааг сайжруулах зорилготойгоор эхлүүлж 2008-2012 он хүртэл жил бүр тасралтгүй зохион байгуулагдсан боловч 2015 оноос хойш Зүүн Хойд Азийн нутаг дахь аюулгүй байдал, улс төрийн асуудлаас болж 3 талын чуулган завсардсан байна.

Хятад-Япон-Солонгосын гурван талт дээд хэмжээний чуулган нь Зүүн хойд Азийн энх тайван, хамтын ажиллагааны санаачлагыг (NAPCI) БНСУ-н засгийн онцгой хүчин чармайлттайгаар тогтмол яриа хэлцэл болгон өргөжүүлж, бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлсэн гэж үздэг. Солонгос, Япон, Хятад улс хооронд гурван талт Цөмийн Эрчим Хүчний Аюулгүй байдлын хамтын ажиллагааны хурал зохион байгуулахыг санаачилжээ. Төрийн тэргүүд бүс нутгийн цөмийн эрчим хүчний хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, цаашид Зүүн Хойд Азийн Цөмийн Аюулгүй байдлын Зөвлөлдөх газартай улс төрийн бодлогыг уялдаатай хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Гурван улсын хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өсч Япон, Солонгос, Хятадын хоорондох хүн, барааны солилцоо ихэсч байна. 1999-2015 онд 3 улсын иргэд хоорондын болон солилцоо 6.58 саяаас 23.76 сая хүртэл нэмэгджээ. Худалдааны хэмжээ 1999 онд 120 тэрбум доллараас 570 тэрбум доллар хүртэл өсчээ.

²⁴⁵ Diplomatic white paper 2016., p. 100

Хойд Солонгостой харилцах харилцаа:

Ерөнхийлөгч асан Пак Гын Хэгийн гадаад бодлого Хойд Солонгостой харилцах харилцааг шинэ түвшинд гаргахад чиглэгдсэн гэж үзэж болно. Тэрээр Солонгосыг нэгтгэх алсын харааныхаа талаар (Дрезденд 2014 оны 3 дугаар сард үг хэлэхдээ) өгүүлэхдээ **нэгт**, хүмүүнлэгийн хамтын ажиллагаанд тулгуурласан интеграци, **хоёрт**, хүн ардын амьжиргааг дэмжих дэд бүтцийг бүтээн байгуулах, **гуравт**, Хойд болон Өмнөд Солонгосыг нэгтгэх интеграци байна хэмээн үзэж байгаагаа илэрхийлээд хоёр Солонгосын хоорондын харилцааг томоохон хэмжээний эдийн засгийн хамтын ажиллагаа болгож тэлэх нь Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрөөс ангижрах эсэхээс шалтгаална гэж үзэж байгаагаа илэрхийлжээ.²⁴⁶

Нэгдэл нь хоёр Солонгосын харилцааны чухал хэсэг байсаар ирсэн бөгөөд нэгдмэл угсаа гарлын илэрхийллээр хуваагдмал байдлыг гэр бүлийн болон улс үндэстний хэмжээнд эцэс болгохыг зорихдоо зардал, сунжирсан хөтөлбөрт анхаарсан хамтын ажиллагааг хамтын үр ашигт болгон өөрчилсөн нь Солонгосын нэгдлийн боломжтой байдлын талаарх асуудлын хүрээг өөрчилсөн гэж үзэхэд хүргэж байна.

Өмнө нь БНСУ-ын засгийн газар “Korean Formula” гэгдэх цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай яриа хэлэлцээрийг сэргээх санааг дэвшүүлж АНУ, Хятад, Орос, Япон зэрэг улсуудтай өргөн хэмжээгээр ярилцаж зөвлөлдсөний дүнд талууд:

1. Хойд Солонгосын цөмийн зэвсгийн хөтөлбөрийг огт дэмжихгүй байх
2. Цөмийн туршилт, урт зайны пуужингийн туршилт зэрэг Хойд Солонгосын стратегийн өдөөн хатгалтад эсэргүүцэл үзүүлэх
3. НҮБ-ийн АЗ-ийн шийдвэрийг үнэнч шударгаар гүйцэтгэх
4. Хойд Солонгосын цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх “судлан нээх хэлэлцээрийг” хийх шаардлага гэж санал нэгтэй байжээ.

Өнөөгийн Солонгосын Хойгийн хурцадмал байдал нь 2016 оны 7 дугаар сард АНУ-Өмнөд Солонгос ТХААД-ыг Өмнөд Солонгост байршуулах хамтарсан шийдвэр гаргасантай холбоотой. БНСУ-АНУ иж бүрэн стратегийн түншлэл Хойд Солонгосын цөмийн болон пуужингийн туршилтууд эхлэсэн үеэс тус улсад шахалт үзүүлэхэд чиглэсээр байсан юм. Харин 2017 оны 2 дугаар сарын 28-нд Өмнөд Солонгосын Засгийн газар Лотте компанитай гэрээ байгуулж, тус компанийн гольфын талбайг цэргийн зориулалтай газар болгохоор болсон байна.²⁴⁷

Пак Гын Хэ төрийн эрхэнд байхдаа ТХААД-ын асуудлыг шууд хөндөхөөс сэргийлэн, “стратегийн тодорхойгүй байдал” буюу “strategic ambiguity” бодлого барьж байсан боловч намынх нь тэргүүлэх албан тушаалтнуудуг батлан хамгаалахын системийг дэмжиж буйгаа ил тодоор илэрхийлж байв.²⁴⁸ Өмнөд Солонгосын Батлан хамгаалахын сайд Han Min-koо “ТХААД систем бол Умард Солонгосын цөмийн аюулын эсрэг хийж буй батлан хамгаалахын хамгийн минимум/бага систем. Хятад

²⁴⁶ Мөн тэнд

²⁴⁷ <https://www.rt.com/news/379054-china-russia-thaad-opposition/>

²⁴⁸ <http://thediplomat.com/2015/04/russia-korean-thaad-deployment-is-a-security-threat/>

улс эл радарыг хэтрүүлэн үнэлж, уг системийг байршуулах асуудлыг хэтэрхий их эсэргүүцэж байна” гэж хэлжээ.²⁴⁹

Ерөнхийлөгч асан Пак Гын Хэгийн ТХААД системийг нутагтаа суурилуулах шийдвэр нь зарим иргэдээс ихээхэн эсэргүүцэлтэй тулсан байна. ТХААД системийг суурилуулах нь Өмнөд Солонгосыг цэрэг зэвсгийн гол бай болгоно гэж зарим иргэд үзэж буй. Солонгосын судлаач Song Dae-sung Орос, Хятадын эсэргүүцлийг Солонгос улс Хятад, Оросын Солонгосын хойгт орж ирэх боломжтой пуужингуудыг эсэргүүцэхтэй адилтгажээ. Тэрээр Хятад, Орос улсууд ТХААД-ыг тэгтлээ үзэн ядаж байгаа юм бол Умард Солонгосын үй олноор хөнөөх зэвсгийг устгахад зоригтой алхам хийх ёстой гэсэн бөгөөд Хятад, Оростой харилцах харилцаанаас болж ТХААД-ыг суурилахгүй байх нь БНСУ үндэснийхээ аюулгүй байдлыг бүрэн огоорсон хэрэг болно гэжээ.²⁵⁰

Хойд Солонгосын цөмийн зэвсгийн хөгжүүлэлт болон урт зайны баллистик пуужингийн туршилтын улмаас олон улсын байгууллагаас түүнд үзүүлэх хүмүүнлэгийн тусламж багассан боловч, БНСУ-ын засгийн газар олон улсын байгууллагууд болон дотоодын төрийн бус байгууллагаар дамжуулан тусламж үзүүлсээр байна. БНСУ-ын засгийн газар Хойд Солонгост зөвхөн хүмүүнлэгийн төдийгүй төрийн бус байгууллагаар дамжуулан соёл болон нийгмийн солилцоо тасралтгүй явагдаж байна. 2015 онд төрийн бус байгууллагын сангаар 11.5 тэрбум воныг өгсөн нь өмнөх оноос 2 дахин их байгаа юм. Засгийн газар Солонгос Хоорондын Хамтын Ажиллагааны Сангаас дотоодын төрийн бус байгууллагуудад 2.3 тэрбум воныг хандивлажээ.²⁵¹

АНУ-тай харилцах харилцаа:

БНСУ-АНУ хоёр талт харилцаа нь Солонгосын дипломат ажиллагааны гол чиг шугам бөгөөд 2015 онд хүчин төгөлдөр болсон “БНСУ, АНУ-ын Цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах хамтын ажиллагааны гэрээ”, 1954 оны “Харилцан батлан хамгаалах гэрээ”, 2012 оны “Чөлөөт Худалдааны хэлэлцээр”-ийн гурван гол чиглэлд хамтын ажиллагааг бэхжүүлэн, холбоотны харилцааг бататгах зорилготой. Ерөнхийлөгч Пак, Обама нарын 2016 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан БНСУ-АНУ-ын Дээд хэмжээний уулзалтаар талууд цахим аюулгүй байдал, сансар огторгуй, цаг уурын өөрчлөлт, эрүүл мэндийн салбарт чиглэсэн хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэхээр тохиролцжээ.

Өмнөд Солонгос, АНУ хамтдаа ТХААД системийг гагцхүү Умард Солонгосын пуужингийн аюулаас хамгаалах зорилготой гэдгийг илэрхийлж байгаа ч Хятад улс үүнийг эсэргүүцэн худалдааны хариу арга хэмжээ авч эхлээд байгаа юм. Эл байдлыг арилгаж, Хятадын талтай харилцаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Өмнөд Солонгосын сангийн сайд Хятадын албаныхныг олон улсын уулзалтуудад түлхүү оруулж байхаа мэдэгдсэн байна. Өмнөд Солонгосын сангийн

²⁴⁹ <http://thediplomat.com/2017/03/us-south-korea-try-to-reassure-china-on-thaad/>

²⁵⁰ <http://thediplomat.com/2015/04/russia-korean-thaad-deployment-is-a-security-threat/>

²⁵¹ Diplomatic white paper 2016., p. 39

сайд мөн Хятадын энэ эдийн засгийн хариу арга хэмжээнүүд Өмнөд Солонгосын эдийн засагт аюул занал учруулж болзошгүйг анхааруулжээ.²⁵²

АНУ бол Солонгосын хоёр дахь том худалдааны түнш бол Солонгос АНУ-н 6 дахь том худалдааны түнш юм. Эдгээр хоёр орны хоёр талт эдийн засаг, худалдааны харилцаа 2012 оны 3 дугаар сарын 15-нд Солонгос-АНУ-ын ЧХХ хүчин төгөлдөр болсноос хойш гүнзгийрэн өргөжсөөр байна. АНУ-д оруулсан Солонгосын хөрөнгө оруулалтын хэмжээ 69.8 тэрбум ам.долларт хүрсэн нь нийт экспортын 13.3 хувийг эзэлж байгаа бөгөөд гол нэрийн бараа, бүтээгдэхүүнд автомашин, автомашины эд анги, гар утас, болон хагас дамжуулагч багтаж байна. АНУ-аас хийгдсэн импортын хэмжээ 44.0 тэрбум ам.долларт хүрсэн нь Солонгосын нийт импортын 10.1 хувийг бүрдүүлж байна. Гол импортын бараа бүтээгдэхүүнд хагас дамжуулагч, хагас дамжуулагч үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, агаарын хөлөг онгоц мөн мах багтаж байна.²⁵³ 1968-2015 оны хооронд Солонгосоос АНУ-д хийгдсэн хуримтлагдсан хөрөнгө оруулалтын хэмжээ 89.9 тэрбум ам.долларт хүрсэн нь Солонгосын хилийн чанадад хийсэн нийт хөрөнгө оруулалтын 20.4 хувийг эзэлж байна. АНУ Солонгос улсын хувьд хамгийн том хөрөнгө оруулагч бөгөөд, хуримтлагдсан нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 1962-2015 онд 62.4 тэрбум ам.долларт хүрчээ.

Хятадтай харилцах харилцаа:

1965 онд дипломат харилцаа тогтоосноос хойш Солонгос, Япон хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа улам нэмэгдсээр байна. Хоёр талын худалдааны хэмжээ 1965 онд 220 сая ам.доллар байсан бол 2011 онд 108 тэрбум ам.долларт хүрчээ. 2015 оны байдлаар Солонгос Япон улсууд бие биенийхээ гуравдахь том худалдааны түнш болсон байна.²⁵⁴ 1968 оноос 2015 оны хооронд Солонгосын Хятадад оруулсан нийт (cumulative) хөрөнгө оруулалтийн хэмжээ 69.86 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 2015 онд Солонгосоос Хятадад оруулсан хөрөнгө оруулалт дангаараа 4.3 тэрбум ам.долларт хүрсэн байна. Хятадын Солонгост хийсэн нийт (cumulative) хөрөнгө оруулалтын хэмжээ дээрх хугацаанд гэхэд 8.11 тэрбум ам.долларт хүрсэн. Хятад улс өөр улс орнуудад хөрөнгө оруулалт хийх сонирхолтой, Солонгос Хятадын капиталыг татахаар ихээхэн хичээл зүтгэл гаргаж байгаа нь цаашид Хятадын Солонгост хийх хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх хандлагатай байна.

2002 оноос хойш БНХАУ нь БНСУ-ын хоёр дахь том түнш, 2003 оноос хамгийн том гадаадын хөрөнгө оруулалтын түнш болсон бөгөөд хоёр улсын худалдааны хэмжээ эрс нэмэгдсэн байна. 2015 оны байдлаар хоёр талын худалдааны хэмжээ 227.4 тэрбум ам.долларт хүрсэн нь Солонгосын нийт гадаад худалдааны 23.6 хувийг бүрдүүлж 1992 оноос хойш 36 дахин нэмэгдсэн байна. Хятадын эдийн засагт “шинэ норм, дэг журам” бий болсон нь Солонгос-Хятадын худалдаанд урьд өмнөх шиг эрс өсөлт ажиглагдахгүй байна.

²⁵² <http://www.reuters.com/article/us-southkorea-economy-china-idUSKBN15A0AI>

²⁵³ Diplomatic white paper 2016., p. 279

²⁵⁴ Diplomatic white paper 2016., p. 273

Хоёр орны зүгээс тарифын бус хориг саадыг харилцан бууруулж, хоёр улсын стратегийн хөгжлийг холбож, санхүүгийн хамтын ажиллагааг дэмжиж, худалдаа хөрөнгө оруулалтыг хөнгөвчилж, дээрх салбаруудад хамтын ажиллагааг улам бэхжүүлэх зорилго бүхий Солонгос-Хятадын ЧХХ-ийг аль болох эрт хүчин төгөлдөр болгохоор хэлэлцсэн. Хятадын “Нэг зам, Нэг бүс” бодлого, Солонгосын “Евразийн санаачлага”-ын хоорондын холбоо хамаарлыг нэмэгдүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг; Үйлдвэрлэл болон шинэлэг аж үйлдвэрийн хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг; Гуравдагч талын зах зээлд хамтарсан хайгуул явуулах ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан. Төрийн тэргүүд мөн санхүүгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, вон-юань чиглэл бүхий худалдааны зах зээлийг Хятадад бий болгохоор хэлэлцжээ.

2015 оны 12 дугаар сарын 20-нд Солонгос-Хятадын ЧХХ хүчин төгөлдөр болсон. Солонгосын хамгийн том худалдааны түнштэй ЧХХ байгуулснаар Хятадын зах зээлд Солонгосын компаниудад илүү их боломж бүрдэж, цаашлаад Солонгосын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх юм. ЧХХ цаашлаад хоёр улсын эдийн засгийн харилцааг иж бүрэн түншлэлийн харилцаанд хүргэнэ гэж үзэж байна. Солонгос улс Хятадын хөдөө орон нутгийн засаг захиргаадтай харилцаагаа хөгжүүлж Хятадын эх газрын Зүүн Хойд болон төвийн бүсэд Солонгосын бизнесийн үйл ажиллагааг дэмжиж байна. Энэ нь дотоодын эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн хооронд илүү тэнцвэртэй өсөлтийг бий болгох нь БНХАУ-ын саяхан баталсан санаачилгатай нийцэж байна.²⁵⁵

Хятад ТХААД-ын асуудлаар хамгийн хүчтэй эсэргүүцэж, мэдэгдэл хийсээр байгаа.²⁵⁶ Хятадын талын үзэж байгаагаар ТХААД систем нь Умард Солонгосын баллистик пуужинг эсэргүүцэх боломжтой байж *магадгүй* ч, хамгийн гол нь Хятадын стратегийн тогтоон барих чадварыг бууруулж, Бээжин, Москвад аюул заналхийлэх тэргүүн зорилготой ажээ.²⁵⁷ Хятад улс АНУ-БНСУ-ын хамтарсан ТХААД систем нь Хятадын үндэсний стратеги, хөгжил цэцэглэлтэд аюул заналхийлж, мөн бүс нутгийн стратегийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлнө гэж мэдэгддэг.²⁵⁸ 2016 оны 7 дугаар сард ТХААД-ыг Өмнөд Солонгост байршуулах шийдвэр гарснаас хойш Хятадын тал Өмнөд Солонгосын эсрэг 43 хариу арга хэмжээ авсан байна. Эдгээрийн 23 нь соёлын холбогдолтой байсан бол 15 нь Өмнөд Солонгосын бизнес, харин 5 нь Сөүлийн дипломат алба, улс төрчид, цэргийнхнийг онилжээ.²⁵⁹ Өмнөд Солонгос нь Хятадын эдийн засгийн хамгийн том түншийн нэг бөгөөд 89 тэрбум ам.доллар буюу Хятадын экспортын 3.8 хувийг эзэлдэг байна. Гэвч Хятадын эдийн засаг ихээхэн хүчирхэг, солонгорсон учир ТХААД-аас болж Өмнөд Солонгост эдийн засгийн хариу арга хэмжээ авах нь өөрт нь

²⁵⁵ Diplomatic white paper 2016., p. 271-272

²⁵⁶ <https://www.rt.com/news/379054-china-russia-thaad-opposition/>

²⁵⁷ <http://carnegieendowment.org/files/CLM52MS.pdf>

²⁵⁸ http://www.upi.com/Top_News/World-News/2017/02/03/Russia-warns-South-Korea-of-consequences-if-THAAD-deployed/8951486133428/

²⁵⁹ http://www.upi.com/Top_News/World-News/2017/02/03/Russia-warns-South-Korea-of-consequences-if-THAAD-deployed/8951486133428/

хүндрэл үзүүлэхгүй юм.²⁶⁰ Энэ хүрээнд Хятад улс К-поп хөгжмийн олон төрлийн бүтээгдэхүүний импортийг хязгаарласан байна.²⁶¹ 2016 оны 6 дугаар сарын 25-нд Орос-Хятад улсууд хамтарсан мэдэгдэлдээ Зүүн хойд Азид ТХААД системийг суурилуулах нь тус бүс нутгийн улсуудын стратегийн аюулгүй байдлын эрх ашигт халдана²⁶² гэж дурджээ.

Японтой харилцах харилцааны онцлог:

Солонгос, Япон нь гагц чухал хөршүүд ч биш, ижил төстэй ашиг сонирхол, үнэт зүйлтэй мөн Зүүн Хойд Азийн энх тайван болон хөгжилд хувь нэмрээ оруулах чухал хамтрагчид юм.²⁶³ 2016 онд Умард Солонгос 20 гаруй баллистик пуужинг Япон тэнгист харваснаар Япончууд аюулгүй байдалдаа ихээхэн анхаарах шаардлагатай болов.²⁶⁴ Өмнөд Солонгосын нутаг дэвсгэрт ТХААД систем суурилуулах тухай Вашингтон, Сөүлийн яриа хэлэлцээг 2016 оны 2 дугаар сард Япон улс дэмжиж буйгаа илэрхийлсэн байна.²⁶⁵ Умард Солонгосын пуужин Японы нутагт унавал засах боломжгүй их хохирол учруулна”, “хэрэв Умард Солонгос хэдэн арван пуужин зэрэг харвавал хариу үзүүлэх ямар ч боломжгүй болно” гэдгийг Японы Батлан хамгаалах Яам²⁶⁶ мэдээлсээр байна. Асахи сонины мэдээлснээр ТХААД-ыг суурилуулахад тулгарч буй хамгийн том бэрхшээл нь эл системийн үнэ өртгийн асуудал байгаа ажээ.²⁶⁷ Өмнөд Солонгосын төрийн тэргүүн Пак Гын Хэ албан тушаалаасаа бууж, сөрөг хүчин гарах магадлалтай байгаа тул Өмнөд Солонгосын нутагт ТХААД-ыг суурилуулахгүй ч байх магадлал бий. Тийм тохиолдолд Япон улс Өмнөд Солонгост суурилуулахаар төлөвлөж байсан ТХААД-ыг илүү хямд үнээр авах боломж гарч магадгүй. Япон улс эдүгээ усан онгоц суурьтай Стандарт Пуужин-3, Эх оронч өндөржүүлсэн хүчин чадавхтай-3 (РАС-3) зэрэг хамгаалагч пуужингуудтай билээ.²⁶⁸

Солонгосын засгийн газар хоёр орны харилцааг гүнзгийрүүлэхэд саад болдог түүхэн маргааныг шийдэх олон янзын санаачилга гаргаж хэрэгжүүлж байна. Тухайлбал, Япон Солонгосын гол асуудал болох Солонгосын эмэгтэйчүүдийг тайтгаруулах асуудал нь зөвхөн Солонгос, Японы хоорондын асуудал бус дэлхийн бүх эмэгтэйчүүдийн эрхийн асуудал хэмээн НҮБ-ын Ерөнхий Ассемблей, НҮБ-ын Хүний эрхийн консул зэрэг байгууллагуудаас дэмжлэг авч асуудлыг аль болох эртхэн шийдэх тал дээр хичээж байв. Эцэст нь Солонгосын засгийн газрын санаачилгаар хохирогчдын нэр төрийн сэргээх, сэтгэлийн шархыг нөхөх төслийн сан байгуулж, түүнд Японы засгийн газар 1 тэрбум иенийг зориулахаар болсон нь солонгосчуудын эгдүүцлийг төрүүлсэн юм.

²⁶⁰ <http://nationalinterest.org/blog/the-buzz/china-really-hates-thaad-so-does-russia-19389>

²⁶¹ <http://www.eastasiaforum.org/2016/09/09/south-koreas-thaad-crisis/>

²⁶² <http://www.eastasiaforum.org/2016/07/16/china-and-russias-north-korea-problem/>

²⁶³ Diplomatic white paper 2016., p. 78

²⁶⁴ <http://www.asahi.com/ajw/articles/AJ201701140038.html>

²⁶⁵ http://noticias.alianzanews.com/309_hispanic-world/3611052_japan-supports-deployment-of-thaad-missile-system-in-south-korea.html

²⁶⁶ <http://www.asahi.com/ajw/articles/AJ201701140038.html>

²⁶⁷ <http://anonhq.com/japan-contemplates-thaad-as-north-korean-tensions-mount/>

²⁶⁸ <http://thediplomat.com/2016/11/japan-gets-serious-about-thaad/>

Япон улс бол АНУ дараагаар орох Солонгосын хоёр дахь том хөрөнгө оруулагч юм. Японы Солонгост оруулсан нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 1962- 2015 онд 39,7 тэрбум ам.долларт хүрсэн нь Солонгосын нийт гадаадын хөрөнгө оруулалтын 15.4 хувийг эзэлж байна. Японы Солонгост оруулсан хөрөнгө оруулалт 2007 оноос хурдацтай өсч Солонгосын гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогын ачаар 2012 онд 4.5 тэрбум ам.долларт хүрчээ. 2013 онд иений ханшийн сулралаас үүдэж Японы Солонгост оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, Солонгосын цахилгааны хураамж 2014 онд 2.5 тэрбум ам.доллар, 2015 онд 1.7 тэрбум ам.доллар болж буурчээ.²⁶⁹ Хоёр талын худалдаа 71.5 тэрбум ам.долларт хүрч 3 дахь том худалдааны хамтрагч болж байгаа юм. Япон руу аялах солонгосчуудын тоо 4 саяд хүрсэн байхад Солонгос руу зочлох Япон аялагчдын тоо Солонгос дахь шувууны ханиадны тархалт, иений ханш сулралт явагдснаар 19.4 хувиар буурч 1838000-д хүрчээ.²⁷⁰

ОХУ-тай харилцах харилцаа:

ОХУ ТХААД-ыг АНУ-ын дэлхийг дамнасан пуужингийн хамгаалах хөтөлбөрийн нэг хэсэг гэж үздэг бөгөөд ТХААД систем нь Оросын хил дагуу байрлах тул Оросын аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй гэж үздэг.²⁷¹ ОХУ ТХААД-ын асуудлаар БНХАУ шиг хүчтэй эсэргүүцэл илэрхийлдэггүй байсан ч 2017 оны 2 дугаар сарын 3-нд ОХУ-аас БНСУ-д суугаа Элчин сайд Александр Тимонин Өмнөд Солонгосын хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Хэрэв энэ системийг байршуулах юм бол Орос улс аюулгүй байдлаа хамгаалах алхам хийхээс өөр сонголтгүй үлдэнэ”²⁷² гэжээ. Хэдийгээр ТХААД систем нь ОХУ, БНХАУ-д шууд аюул занал учруулахгүй боловч эл системийн радар нь эдгээр хоёр улс тив дамнасан пуужин харвахад хяналт тавих боломжийг АНУ-д олгох юм.²⁷³ Одоогийн ТХААД-ын AN/TPY-2 радарын хүчин чадавх нь 600-900 км-т хязгаарлагддаг боловч үүний цар хүрээг 2000 км-т хүргэж нэмэгдүүлэх боломжтой төдийгүй Хятадын нутаг дэвсгэр болон Оросын Алс дорнодын ихээхэн хэсгийг хянах боломжтой юм. Оросын судлаачийн үзэж буйгаар ТХААД систем нь Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийг зогсоож чадахгүй бөгөөд Умард Солонгос одоогийн баллистик пуужингийн болон шумбагч онгоцны пуужингийн системийг сайжруулах шаардлагатай гэж үзжээ. Мөн энэ үйл явц нь Орос, Хятадыг хариу арга хэмжээ авахад хүргэж, бүс нутагт цэрэг зэвсгийн эцэс төгсгөлгүй уралдааныг бий болгох юм.²⁷⁴ Орос нь Өмнөд Солонгосын эсрэг Хятад шиг эдийн засгийн арга хэмжээ авахад хүндрэлтэй. Учир нь БНХАУ-аас эдийн засгийн хараат байдлаас гарахын тулд ОХУ Азийн бусад улсуудтай эдийн засгийн харилцаагаа хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа учраас Өмнөд Солонгост эдийн

²⁶⁹ Diplomatic white paper 2016., p. 274

²⁷⁰ Diplomatic white paper 2016., p. 84

²⁷¹ http://www.upi.com/Top_News/World-News/2017/02/03/Russia-warns-South-Korea-of-consequences-if-THAAD-deployed/8951486133428/

²⁷² http://www.upi.com/Top_News/World-News/2017/02/03/Russia-warns-South-Korea-of-consequences-if-THAAD-deployed/8951486133428/

²⁷³ <http://rbth.com/opinion/2017/03/01/moscow-beijing-thaad-south-korea-711238>

²⁷⁴ Мөн тэнд.

засгийн хориг арга хэмжээ авбал өөрт нь илүү хүнд тусах юм.²⁷⁵ ОХУ нь БНСАУ, БНСУ аль алинтай нь эдийн засгийн томоохон төслүүд хэрэгжүүлэх сонирхолтой байгаа юм. Rajin-Khasan ложистикийн төсөл нь Транс Сибирийн Оросын төмөр зам болон Хойд Солонгосын Ражин боомт холбож Оросоос нүүрсийг ачин хоёр Солонгост тээвэрлэх анхны төсөл юм. ОХУ-ын зүгээс барууны орнуудын тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээтэй холбогдуулан Ази тиврүү чиглэсэн бодлогоо эрчимжүүлж “2025 он хүртэл Алс Дорнод-Байгалийн хөгжлийн стратеги” гэсэн нэртэй дэд бүтцийн томоохон төслүүдээ хэрэгжүүлэхээр зорьж байна. 2018 онд багтаан 19620 км урт байгалийн хийн хоолой, 4000 м урт шинэ төмөр зам, 7000 м урт авто зам, 2 далайн боомт шинээр барим, 2 УЦС ашиглалтанд оруулах, 8 АЦС ашиглалтанд оруулах том зорилт тавьсан байна.

ТХААД эсэргүүцэхэд ОХУ БНХАУ-тай ижил байр суурьтай ч саяхныг хүртэл харьцангуй нам жим байсан юм. Харин 2 сард Оросын Элчин сайд “Орос өөрийн аюулгүй байдлаа хамгаалахаас өөр замгүй үлдэнэ” гэсэн нь хэрэв ТХААД системийг байршуулбал тус бүс нутаг (Оросын хувьд Алс дорнод) дахь цэрэг, зэвсгийн тоогоо нэмэгдүүлэх зэргээр хариу арга хэмжээ авах төлөвлөгөөтэй байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч Орос нь Азийн улс орнуудтай эдийн засгийн харилцаагаа нэмэгдүүлэх эрмэлзэлтэй байгаагийн хувьд Өмнөд Солонгосын эсрэг Хятад шиг эдийн засгийн арга хэмжээ авахад хүндрэлтэй юм.

БНСУ-ын эдийн засгийн гадаад бодлогын онцлог:

БНСУ-ын эдийн засгийн гадаад бодлогын онцлог нь бүс нутгийн чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, ХАЁТ буюу зээл тусламжийн бодлогыг эрчимжүүлэх, эрчим хүчний дипломат бодлогыг өргөжүүлэх гэсэн 3 чиглэлд түлхүү анхаарч байна гэж үзэж болохоор байна.

1. Бүс нутгийн ЧХХ байгуулах хүрээнд:

2016 оны 12 дугаар сард БНСУ-Хятадын ЧХХ хүчин төгөлдөр болсноор Солонгос улс нь дэлхийн хамгийн том 10 худалдааны эдийн засгуудаас АНУ, Хятад, ЕХ-той нэгэн зэрэг ЧХХ баталсан ганц орон болсон юм. Эдийн засаг, худалдааны хувьд Чөлөөт Худалдааны Гэрээг Хятад, Европын Холбоо, Канад, Вьетнам, Шинэ Зеландтай байгуулснаар Солонгосын худалдааны хамрах хүрээ ихэссэн.²⁷⁶

БНСУ гадаад зах зээлээ тэлэх зорилгоор ЭСЯ-уудаараа дамжуулан идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээрээр дамжуулан хилийн чанадад хэрэгжүүлсэн төслийн нийт өртөг 6,570 сая ам.доллараас багагүй байна. Солонгосын ЭСЯ-ууд гаалийн тариф, гадаад зохицуулалт, корпорациудын гадаадын засгийн газруудаас тулгасан аливаа асуудлыг шийдвэрлэж нийтдээ 470 сая ам.долларыг ач холбогдолгүй зардлыг хэмнэжээ²⁷⁷.

²⁷⁵ <http://nationalinterest.org/blog/the-buzz/china-really-hates-thaad-so-does-russia-19389>

²⁷⁶ Diplomatic white paper 2016., 385

²⁷⁷ Diplomatic white paper 2016., p. 30-31

БНСУ-ын Гадаад хэргийн Яам демпингийн эсрэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гадаад орнуудаас тавьсан саармагжуулах арга хэмжээ зэрэг аливаа худалдааны маргаан, асуудлыг шийдвэрлэхэд дотоодын компаниудад туслах зорилготой хичээн ажиллаж байна. 2000 онд Худалдааг зохицуулах ажлын хэсэг (Trade Remedy Reaction Team) мөн Хоёр талт худалдааны Газар байгуулагджээ. Эдгээр нь Солонгосын компаниуд худалдааны аливаа шударга бус асуудалд өртсөн тохиолдолд худалдааг зохицуулах ажлын хэсэг, асуудлыг шийдвэрлэх гадаадын эрх бүхий шалгах байгууллагатай хамтарч асуудлыг шийдвэрлэдэг байна. 2015 оны сүүлээр гэхэд 162 гадаад худалдааны асуудал, 106 демпингийн эсрэг арга хэмжээ, 8 саармагжуулах татвар, арга хэмжээ, 61 урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан нь өмнөх оны мөн үеэс 8 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.²⁷⁸

2. ХАЁТ-ийг нэмэгдүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх хүрээнд:

Солонгосын засгийн газар нь 2020 онд дотоодын нийт хөрөнгө оруулалтынхаа 0.2 хувийг ХАЁТ-д, 2030 он гэхэд ЭЗХАХБ-ын ХТХ-ны дундаж хувь болох 0.3 хувь болгож нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна. Солонгос улс нь Азид төвлөрсөн ХАЁТ бодлогыг баримтлахын хамт Африкийн нэн чухал салбарууд болох нийгмийн эрүүл мэнд, боловсрол, болон хөдөө орон нутгийн хөгжил зэрэг салбарт ХАЁТ-г нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.²⁷⁹ Солонгосын засгийн газрын 2015 оны тусламжийн 60 хувийг ХАЁТ-ын нэн чухал хамтрагч улсуудад “чухалчилсан төвлөрөл” гэсэн дүрмийн дагуу хөгжлийн үр нөлөөг нь сайжруулахын тулд зориулжээ. Салбарын хуваарилалтын хувьд 50 орчим хувь нь боловсрол болон нийгмийн эрүүл мэнд, тээвэрлэлт, эрчим хүч гэсэн хэсгүүдэд хуваарилагджээ. Мөн бусад голлох салбаруудад нь ус цэвэршүүлэлт, ХАА болон хөдөө орон нутгийн хөгжүүлэлт, төрийн удирдлага оржээ. Хөгжлийн албан ёсны тусламжийн 1.458 сая ам.долларыг (76.3 хувь) хоёр талт тусламжийн хүрээн, 453 сая ам.долларыг (23,7 хувь) олон талт тусламжид хуваарилан зарцуулсан байна. Солонгос нь бүс нутгын байгууллагууд болох ОУИНБ, Нордикын улсууд, Еврази тивийн улсуудтай харилцаагаа сайжруулж Монгол, Орос, Хятад, Солонгосыг хамарсан Түмэн голын санаачилгыг хэрэгжүүлэх, олон улсын байгууллага болгох зорилготой байна. Түүнчлэн, Солонгос улс нь KSP-ээр дамжуулан эдийн засгийн харилцан ашигтай бүтэцтэй улсуудын ICT (мэдээлэл технологийн салбар), байгаль орчны хамгаалал, ХАА зэрэг салбаруудад Солонгосын техник технологи туршлагыг нэвтрүүлэн бүтээлч экосистемийг бий болгоход анхаарч байна.²⁸⁰

Солонгосын гадаад бодлогын нэгэн чухал хэсэг нь эрчим хүчний дипломат ажиллагаа юм. Энэ стратеги нь байгалийн баялагтай орнуудтай аль болох ойр дотно харилцаатай байхыг эрэлхийлдэг юм. Солонгосын үндэсний эрх ашигт нийцүүлэн тусламж өгөх үзэгдэл нь Европ, Хойд Америкийн үйл ажиллагаатай зөрчилдөх тал байгаа юм.

²⁷⁸ Diplomatic white paper 2016., p. 280-283

²⁷⁹ Мөн тэнд, 2016., p. 333

²⁸⁰ Мөн тэнд, 2016., p. 106-108

3. Эрчим хүчний дипломат ажиллагаа:

2015 оны 11 сард Парис хотноо зохион байгуулагдсан COP21 уулзалтаар АНУ-н Ерөнхийлөгч Барак Обама шинэчлэл хийхийг санаачилсан юм. Уг шинэчлэл нь БНСУ, АНУ, Их Британи, Япон, Хятад зэрэг тэргүүлэх 20 улсыг багтаасан цаг уурын өөрчлөлтөд эерэг нөлөө бүхий технологийн дэвшлийг дараагийн 5 жилд нэвтрүүлэх зорилгоор цэвэр эрчим хүчний судалгаанд төсөвлөх хөрөнгө оруулалтын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэх зорилго бүхий олон улсын үүрэг амлалт явдал юм.

БНСУ нь Олон улсын Эрчим хүчний Агентлаг (IEA), Олон улсын Сэргээгдэх Эрчим хүчний Агентлаг (IRENA), OECD /Цөмийн эрчим хүчний Агентлаг (OECD/NEA) мөн G20-ийн цаг уурын өөрчлөлтөд чиглэсэн эрчим хүчний зохистой хэрэглээг дэмжих арга хэмжээнүүд зэрэг олон улсын эрчим хүчний талаарх аливаа яриа хэлэлцээрт идэвхитэй оролцдог билээ.²⁸¹ 2015 онд 50 дипломат төлөөлөгчийн газрууд, 26 эрчим хүчний зөвлөх газруудаар дамжуулан Солонгосын эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж үйлдвэрүүд хилийн чанадад шинээр бизнес эрхлэхэд чухал түлхэц үзүүлсээр ирсэн байна. Эдгээр 50 дипломат төлөөлөгчийн газруудыг байгалийн баялгийн нөөцтэй, эсвэл эрчим хүчний өсөн нэмэгдэх зах зээлтэй орнуудад байрлуулснаар суугаа орны засгийн газартай хамтарч эрчим хүч, нөөц баялгийн талаарх арга хэмжээ зохион байгуулж, мэргэжлийн сүлжээ байгуулах мөн тус орны эрчим хүчний нөөц баялгийн талаар сүүлийн үеийн мэдээлэл цуглуулан хоёр талт харилцааг хөгжүүлэх боломж бүрдүүлдэг.²⁸²

БНСУ-ийн удирдлага дор байгуулагдсан Дэлхийн Ногоон Өсөлтийн Институт (GGGI) олон улсын байгууллагад гишүүн орнуудын тоо нэмэгдсээр байна. Дэлхийн Ногоон Өсөлтийн Институци (GGGI) Филиппин, Монгол, Этиоп зэрэг 20 гаруй орнуудын ногоон хөгжлийн стратеги, түүний биелэлтийг хангахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Дэлхийн Ногоон Өсөлтийн Институт (GGGI) байгууллагын чадавхийг сайжруулахад чиглэсэн 2015-2020 оны дунд хугацааны стратегийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Солонгосын засгийн газар тус байгууллагын гишүүнчлэлийг хөхүүлэн дэмжиж, хоёр талт уулзалт, хамтарсан хороо, мөн олон улсын хурал зохион байгуулах зэрэг шаардлагатай дипломат арга хэмжээг зохион байгуулахад хувь нэмэр оруулж байна.

Солонгосын засгийн газар цаг уурын өөрчлөлтийн эсрэг Солонгосын хийж буй бизнес загварын 4 төрөл болох эрчим хүчийг хадгалах систем (ESS)-тэй хавсарч сэргээх эрчим хүчээр цахилгааний хэрэглээг хангах; ногоон эрчим хүчний хотууд; цахилгаан тээврийн хэрэгсэл ба түүнтэй холбоотой дэд бүтэц, ухаалаг фермтэй холбоотой хөгжиж буй орнуудын хэрэгжүүлэх Ногоон цаг уурын Сан” (GCF)-ийн төслүүдийн судалгааг хөхүүлэн дэмжиж байна. Хүрээлэн буй орчны хамтын ажиллагааны Хятад, Япон, Оростой хоёр талт нэгдсэн хороодоор дамжуулан агаар, далайн бохирдол, цаг уурын өөрчлөлт, далайн хог хаягдал зэрэг өргөн хүрээг

²⁸¹ Diplomatic white paper 2016., p. 260-261

²⁸² Ibid, 2016., p. 261

хамарсан хамтын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх мөн хүрээлэн буй орчны бодлогыг дахин нягтлаж үзэх зэрэг ажилд идэвхитэй оролцож байна.

4. МОНГОЛ-БНСУ-ЫН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

БНСУ 1980-аад оны сүүлээс “Нордполитик” хэрэгжүүлж эхэлснээр Зүүн Европ, ЗХУ, Хятад зэрэг социалист системийн улсуудтай харилцаагаа хэвийн болгоход анхаарсны дүнд хоёр талын харилцаа сайжирч 1990 оны 3 дугаар сард албан ёсоор дипломат харилцаа тогтоожээ. 1990-ээд оны дундуур UNDP (НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр)-гээс хэрэгжүүлсэн Хойд Солонгос, Хятад, Орос гурван улсын хил орчим Түмэн гол бүсийн хөгжлийн хөтөлбөрт Солонгос, Монгол нь гишүүн улсын хувьд хамтран оролцож олон талт хамтын ажиллагаанд тулгуурласан Зүүн Хойд Азийн бүс нутгийг хөгжүүлэх суурь тавигдсан билээ.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогод БНСУ нь хүндтэй байрыг эзэлдэг юм. Хил залгаа хоёр хөршөөс гадна Монгол улсын эдийн засаг, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтад өнгөрсөн хугацаанд зохих хувь нэмрээ оруулсаар ирсэн юм. БНСУ нь Монгол улсын худалдааны Хятад, Орос, Японы дараа ордог 4 дэх түнш бөгөөд нийт экспортын 1,6 хувь, импортын 7,1 хувийг эзэлдэг. Харин Солонгос улсын нийт худалдаанд Монгол улсын эзлэх жин хэмжээ одоогоор 0.1 хувьд ч хүрэхгүй маш бага хэмжээтэй болно. Манай улсаас голчлон молибдений хүдэр, баяжмал, мал амьтны үс, хялгас зэрэг байдаг бол БНСУ-аас газрын тосны бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа, машин, тоног төхөөрөмжийг импортлодог байна.

Хөрөнгө оруулалтын тухайд 1990-2015 оны хооронд нийт 755,3 сая ам.долларт хүрсэн, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 2309 компани Монгол улсад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.²⁸³ 1994-2015 оны хугацаанд Солонгосын Монгол дахь шууд хөрөнгө оруулалт хуримтлагдсан дүнгээр 428 сая 840 мянган доллар бол энэ хугацаан дахь Солонгосын хилийн чанад дахь нийт хөрөнгө оруулалтын хэмжээний ойролцоогоор 0.1 хувьтай тэнцэх үзүүлэлттэй байна. Солонгосын шууд хөрөнгө оруулалтыг 2015 оны нийт хуримтлагдсан дүнгээр авч үзвэл уул уурхайн салбар 27.4 хувь, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 17.2 хувь, барилгын салбар 12.8 хувь, үл хөдлөх хөрөнгө болон түрээсийн салбар 12.1 хувийг эзэлж байна. Монгол дахь Солонгосын шууд хөрөнгө оруулалтын тухайд 1990-ээд онд гол төлөв бөөний болон жижиглэнгийн худалдаа, зочид буудал, нийтийн хоолны салбарт голчилдог байсан бол 2000 оноос хойш хэвлэл, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай зэрэг олон салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлжээ. Нэн ялангуяа уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт 2008 оноос хойш нэмэгдсэнээс гадна барилга, газар тариалангийн салбар дахь хөрөнгө оруулалт тасралтгүй өсөх хандлагатай байна.

²⁸³ БНСУ дахь МУ-ын ЭСЯ-ны цахим хуудас: http://www.mfa.gov.mn/?page_id=18591#1491440343455-a997dc9d-87a5

БНСУ нь манай улсад 1991 оноос буцалтгүй тусламж, 1993 оноос хөнгөлттэй зээл олгож ирсэн. 1991-2015 оны хооронд нийт 50 төсөлд 114,9 сая ам.долларын буцалтгүй тусламж олгожээ. 1993-2010 онд нийт 85 сая ам.долларын хөнгөлттэй зээл олгосон. 2015-2018 онд 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл авахаар ЗГ хоорондын ерөнхий хэлэлцээр байгуулжээ. 2013 онд БНСУ Монгол улсыг буцалтгүй тусламж үзүүлэх тэргүүлэх ач холбогдолтой эхний 10 оронд хамруулсан бөгөөд жилд 20 сая хүртэл ам.долларын тусламжийг үзүүлэх боломжтой гэж үздэг. Эдийн засгийн хамтын ажиллагааны сан (EDCF)-аас 2015-2018 онд авах 300 сая ам.долларын ЗГ хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд 55,5 сая ам.долларын “Үндэсний оношлогоо, эмчилгээний төв байгуулах” төсөл хэрэгжиж, улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл, Ухаалаг боловсрол төслийн зээлийн гэрээ хийгджээ.²⁸⁴

Хоёр орны дипломат, албан паспорттой иргэд 30 хоног визгүй, энгийн паспорттой иргэд 90 хоногийн визтэй харилцан зорчдог. 2016 оны 9 дүгээр сарын байдлаар 53627 монгол иргэн БНСУ-д, 2016 оны 6 дугаар сарын байдлаар 17366 солонгос иргэн Монгол Улсад харилцан зорчсон байна.²⁸⁵ БНСУ-ын Хууль зүйн яамны Цагаачлалын албаны мэдээгээр 2016 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар манай улсын 35091 иргэн тус улсад урт болон богино хугацаагаар байнга оршин сууж байна. БНСУ-д манай улсын 46312 иргэн зорчсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10,2 хувиар өссөн байна.

Боловсролын салбар дахь хамтын ажиллагаа өргөжиж 1991 оноос хойш 2017 он хүртэл хугацаанд МУ-ын 3000 иргэн БНСУ-д суралцжээ. Боловсролын салбарт 19,6 сая ам.долларын хөнгөлөлттэй “Ухаалаг боловсрол төсөл” 2015 оноос хэрэгжиж эхэлсэн. Соёлын талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын хороо хоёр жил тутам хуралддаг бөгөөд “2016-2019 оны соёлын солилцооны тухай Засгийн газар хоорондын хөтөлбөр” шинэчлэн байгуулаад байна. Монгол Улс 2012 оноос Сөүлд, БНСУ 2015 оноос Улаанбаатар дахь ЭСЯ-нд тус тус цэргийн атташе томилон ажиллуулж байна.

БНСУ-д Монгол судлал тасралтгүй хөгжсөөр байна. Монгол хэл, түүх, соёл, эдийн засгийн чиглэлээр Солонгосын монголч эрдэмтдийг нэгтгэдэг олон нийтийн байгууллага өргөжиж 220 гишүүнтэй. Өнгөрсөн хугацаанд Монголын эртний түүх, археологи, монгол хэл шинжлэлийн чиглэлээр Монголын нууц товчооны судалгаа, Дорнод Монголын хамтарсан судалгаа /Сүхбаатар аймгийн Дарьганга/, Өвөр Монгол, ОХУ-ын Иркутск, говийн бүсийн судалгаа, Жэжү арлын морь, нүүдэлчдийн соёлын хэлхээ холбооны талаар судалгаа хийж, “Монгол судлал” товхимлыг жилд 2 удаа хэвлүүлэн гаргадаг болсон байна.

²⁸⁴ БНСУ дахь МУ-ын ЭСЯ-ны цахим хуудас: http://www.mfa.gov.mn/?page_id=18591#1491440343455-a997dc9d-87a5

²⁸⁵ Мөн тэнд

ДҮГНЭЛТ

БНСУ “Евразийн санаачилга” бодлогыг хэрэгжүүлэх стратегийн онцлогыг харгалзах:

- Өмнөд Солонгосын хөгжлийн гол стратеги зорилго, алсын хараа бол “нэгдмэл, бүтээгч, амар амгалан Еврази”-ийг цэцэглэн хөгжүүлэхэд тээвэр, ложистикийн сүлжээ, цахим дижитал сүлжээ, Солонгосын соёлын хамтын ажиллагаагаар дамжуулан оролцох явдал хэмээн үзэж байна.
- Энэ 3 хэлбэрээр хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд Евразийн бүс нутаг дахь улс орнуудад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн интеграцийг эрчимжүүлэх шаардлагатай гэж үздэг бөгөөд хамтран ажиллах боломж, зорилгоо ярилцан хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдээ тохирч сонгож байна.

БНСУ нь “Евразийн санаачилга”-ын бодлогоо хэрэгжүүлэх 4 стратегийг сонгож байна. Үүнд:

1. Тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлэхэд дэд бүтэц барих, аж үйлдвэрийн цогцолбор төвүүд, усан боомтын эдийн засгийн нөлөөллийн бүс байгуулах замаар оролцох
2. Аж үйлдвэр худалдааг өргөжүүлэх, ГХО-д таатай боломж олгох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
3. ХАА-н салбар, загасны аж ахуйг хамтран хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх
4. Эрчим хүч, байгалийн нөөц баялагийг ашиглахдаа баримталж буй гол зарчим урт хугацааны эрчим хүчний нөөцийг тогтвортой нийлүүлэх, тээврийн аюулгүй байдлыг хангах

Энэ хүрээнд Евразийн бүс нутагт орших улс орнуудтай хамтран ажиллахдаа:

- Эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд олон талын оролцоотой тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлэх, хэт өндөр хурдны харилцаа холбооны сүлжээ байгуулахыг чухалчлан үзэж байна.
- Бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд Төв Ази, ОХУ болон Монгол Улс, Хойд Солонгос, АСЕАН-ны орнуудтай харилцаагаа өргөжүүлэхэд илүү анхаарал хандуулж байна.
- Эдгээр бүс нутаг, улс орнуудтай харилцахдаа худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжихийн зэрэгцээ бизнесийн орчинг сайжруулж, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарч байна.
- БНСУ-ын бусдаас онцлог санал болгож буй 1 том төсөл бол “Торгоны замын буухай шуудан” юм. Далайн томоохон боомт хотуудыг хуурай газрын дэд бүтцийн сүлжээтэй холбохын тулд Хойд Солонгостой харилцах харилцааг сайжруулах, улмаар БНСУ-Хятад-Хойд Солонгос болон БНСУ-ОХУ-Хойд Солонгос гурвалсан хамтын ажиллагааг тус тусад нь хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

- Улс орнуудтай харилцахдаа баримталж буй голлох тактик бол Засгийн Газар, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн оролцогчидтой тээвэр, аж үйлдвэр, ХАА-н салбар болон байгаль орчны салбарт хамтран ажиллахдаа хөрөнгө оруулалтыг дэмжих, өөрийгөө таних үйл явцад дэмжлэг үзүүлэх замаар бизнесийн шинэ загвар туршихад оролцох явдал юм.
- Хоёр болон олон талт хамтын ажиллагааны механизмыг ашиглан өндөр дээд хэмжээний уулзалт, тээврийн яамны сайд нарын уулзалт (БНСУ+Хятад, БНСУ+Хятад+Япон г.м.) бол бүс нутгийн болон дэд бүс нутгийн хэмжээнд Түмэн гол төслийн санаачилга зэрэг олон улсын түншлэлийг бэхжүүлэхэд түлхүү анхаарч байв.

1. Тээвэр, ложистикийн сүлжээ: цахим сүлжээ /Digital networking/

- Хятадын “Нэг зам, Нэг бүс” бодлогын нөлөө 6 эдийн засгийн коридор байгуулах төслийн чиглэл, зорилгоор дамжин хүчтэй нөлөөлж байна. Эхний эдийн засгийн коридор нь Хятад-Монгол-Орос улсын хооронд хэрэгжих “Цайны зам” бөгөөд ЗХА-ийн бусад улс орнууд татагдан орох боломжтой. Энэ үүднээс өмнөд Солонгосын оролцох сонирхол өндөр байна.
- БНСУ-ын зүгээс Еврази болон Төв Азийн орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх 5 чиглэл, хэлбэрүүд хүчтэй байна. Үүнд: бодлого зохицуулах механизм (policy coordination), дэд бүтэц, худалдаа, санхүү, хүн амын шилжих хөдөлгөөн ба соёлын солилцоо орж байна.
- Дэд бүтцийн салбарт эрчим хүчний сүлжээ, тээврийн сүлжээ (авто зам, төмөр зам, өндөр хурдны галт тэрэг боомтын сүлжээ) голчлон яригдаж байна.

2. Эрчим хүчний зах зээлээ тэлэх:

- БНСУ нь АНД-н бүс нутгийн эрчим хүчний нөөц багатай, гадны импортоос хамааралтай тэргүүлэх 5 улсын нэг юм. Газрын тосны 4 дэх импортлогч, нүүрсний 3 дахь том хэрэглэгч, АНД-н бүс нутгийн 2 дахь том байгалийн хий импортлогч улс юм. Тиймээс Төв Азийн 5 улс, ОХУ, Монгол улстай эрчим хүчний төслүүдийг хамтарч хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч байна. Ингэхдээ газрын тосны нөөц, СЭХ (далайн ус, нар) илүү сонирхож байна.
- БНСУ-ын ЗГ 2013 оноос ЗХА-д ГТБ бүтээгдэхүүн нөөцлөх, боловсруулах, худалдааны гол төв болох томоохон зорилт тавьж, нөөцийн хэмжээгээ нэмэгдүүлэх дэд бүтцээ сайжруулах, татварын хөнгөлттэй орчин бий болгох, мөрдөх журмаа цэгцлэх талаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. ЗГ-аас уг төсөлд 2 триллион вон (1.9 тэрбум ам.доллар)-ы хөрөнгө оруулалт хийхээр батлагджээ. Төсөл хэрэгжсэнээр БНСУ нефтийн нөөц, худалдаа эрхлэлтээр дэлхийн 4 том төвийн нэг болох юм. Тиймээс Монгол улс БНСУ-ыг газрын тосны салбарт татан оролцуулж Хятадын монополь нөлөөг бууруулах боломжтой.

- 2015 онд сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлт, дэд бүтэц, байгууламжийг барьж байгуулах төсөвт 548.6 тэрбум вон зарцуулахаар баталсан нь МУ-ын СЭХ-ний эх үүсвэрийг 2020 онд 30 хувьд хүргэх стратеги зорилгод хүрэхийн тулд ХО-ыг татах боломж байна.

Эцэст нь дүгнэж үзэхэд БНСУ-ын эдийн засгийн гадаад харилцааны онцлог нь ЧХХ байгуулах замаар Солонгос бараа, үйлчилгээний худалдааг өсгөх, ХАЁТ-ыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалтаа тэлэх, эрчим хүчний дипломат ажиллагаагаар дамжуулан нөөц баялагтай орнуудаас стратегийн нөөцийн нийлүүлэлтийн сувгийг нэмэгдүүлэх замаар аюулгүй байдлаа хангахад түлхүү анхаарч байна. Энэ ашиг сонирхлыг Монгол улс БНХАУ-аас хэт хамааралтай байгаа эдийн засгийн гадаад бодлогоо тэнцвэржүүлэхэд ашиглах нь зүйтэй юм.

НОМ ЗҮЙ

1. Mireya Solis., South Korea's Fateful Decision on the Trans-Pacific Partnership.
2. Foreign Policy at Brookings. Policy paper, number 31, September 2013
3. Heike Hermanns., "National Role Conceptions in the Global Korea Foreign Policy Strategy", The Korean Journal of International Studies, Vol.11, No.1 (June 2013), 55-82
4. LEE Jae-YUONG, GWUN Ka Woen. Korea-Mongolia Economic Relations: How Can They Be Reinforced?, World Economy Brief.Vol.6, No.21 ISSN2233-9140
5. Alicia Campi., The New Great Game in NEA: Potential impact of energy mineral development in Mongolia on China, Russia, Japan and Korea. Asia-Pacific Policy Papers Series, The Edwin O.Reischauer Center for East Asian Studies, John Hopkins University.
6. "Asian Continentalism:furthering connections between East and West" Conference Proceedings, 2015
7. Sun Jun Park., "Korean Road to Developing Intermodal Transport System" Korean Maritime Institute, National seminar on Integrated Intermodal Transport Connectivity, 2015
8. Korean Diplomatic white paper 2016., p. 357-358 www.mofa.go.kr
9. Global Asia., volume 12, number 1, 2017
10. Eurasian Initiative., MOFA www.mofa.go.kr
11. Ulaanbaatar Dialogue., Ministry of Foreign Affairs Mongolia, <http://www.mfa.gov.mn/>
12. Research materials from KIEP: www.kiep.kr